

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”
Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын төслийн зорилго нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсөвт өртгийн үндэслэлгүй өсөлтийг бууруулах, зогссон болон үр ашиггүй төслүүдийг эрэмбэлэх, төлөвлөлт болон шийдвэр гаргалтыг ил тод, өгөгдөлд суурилсан болгох, мөн төсвийн сахилга бат, хариуцлагыг бэхжүүлэхэд оршино.

Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд нийт 579 төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр тусгасны 2.0 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 136 төсөл, арга хэмжээний анх батлагдсан төсөвт өртөг нь 805.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Монгол Улсын 2024, 2025 оны улсын төсөв, 2026 оны төсвийн төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр тусгасан нийт төсөл, арга хэмжээний давхардлыг нь арилгаж үзэхэд 3 жилийн хугацаанд 2010 оноос хойш анх батлагдаж төсвөөс санхүүжүүлж ирсэн 522 төсөл, арга хэмжээний анх батлагдсан төсөвт өртөг 2026 оны байдлаар 1.9 их наядаар нэмэгдсэн дүнтэй харагдаж байна. Энэ нь улсын төсөвт ихээхэн хэмжээний дарамт үзүүлж, төсвийн хөрөнгө оруулалтын бодлого алдагдуулах, улмаар төсвийн хөрөнгө оруулалтаар цаашид санхүүжүүлж болох нийгэм, эдийн засгийн олон үр дүнтэй төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх боломжийг хязгаарлан өмнөх төслүүдийн нэмэгдсэн дүнг санхүүжүүлэхэд зарцуулж байгааг цаашид залруулах шаардлагатай байна гэж үзэж тухайн асуудлаар “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачилсан болно.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг олон талын оролцоонд тулгуурлан боловсронгуй болгох зорилгоор мэргэжлийн байгууллага, холбоод, холбогдох мэргэжилтнүүдийн дунд нээлттэй хэлэлцүүлгийг 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд 41 мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулсан. Мөн олон нийтийн санал авах зорилгоор D-Parliament.mn цахим сүлжээнд 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр байршуулсан.

Засгийн газраас санал авах хүсэлтээ 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдөр УИХ – 03/12077 тоот албан бичгээр уламжилсны үндсэн дээр Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 35 дугаар хуралдааны тэмдэглэлийг хүргүүлсэн. Тус хуралдааны тэмдэглэлээр Засгийн газар зарчмын хувьд дэмжсэн бөгөөд уг саналыг 2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн ХЭГ/82 дугаартай албан бичгээр албажуулан ирүүлсэн. Засгийн газраас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий

болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна” гэж заасан тул тогтоолын төслийн нэрийг төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай үүнтэй уялдуулан тогтоолын төслийн 1, 2 дох заалтын “улсын төсвийн” гэснийг “төсвийн” гэж тус тус өөрчлөх санал гаргасан.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг нь 4 заалттай ба 1-р заалт нь дотроо 5 дэд заалттайгаар боловсруулсан болно.

---o0o---